



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 4/256

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XXIV хуралдааны 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхдийн Паркад засвар үйлчилгээ хийхэд шаардагдах зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Тус зардлыг Эрх зүйн нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгогдсон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах зардлаас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Хүүхдийн Паркыг засварлаж, хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгож ажиллахыг хүүхдийн “Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (М.Сарангэрэл), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

